



МОНГОЛ УЛС  
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Утас: 31-03-92, Факс: (976-11) 31-14-71,  
<http://www.mongolbank.mn>

2014.05.27 № А-1/603  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН  
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА Б.ГАРАМГАЙБААТАР ТАНАА

Улсын Их Хурлаас 2014 оны 5 дугаар сарын 08-ны өдөр баталсан “Эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 34 дүгээр тогтоолын хавсралтын 1.10 дахь чиглэлд заасны дагуу Монголбанк, Засгийн газрын хамтран хэрэгжүүлж байгаа “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-т дүн шинжилгээ хийж, тайланг хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авч танилцана уу.

Хавсралт 25 хуудастай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

14 1949


A5-2014.doc

## ГОЛ НЭРИЙН БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг бууруулах, иргэдийн хэрэглээний гол нэрийн барааны үнийн өсөлтийг бага байлгах замаар бага, дунд орлоготой иргэдийн бодит орлогыг хамгаалах, дунд хугацаанд бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамжийн үр ашигтай, зах зээлийн зарчимд суурилсан тогтолцоог бүрдүүлэх, бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлийг санхүүжүүлэх санхүүгийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх зорилгоор Монголбанк, Засгийн газар хамтарч, “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг 2012 оны 10 дугаар сараас хэрэгжүүлж байна.

Энэхүү хөтөлбөрийн үр дүнд мах, гурил, шатахууны жижиглэнгийн худалдааны үнийн өсөлт өмнөх онуудтай харьцуулахад эрс буурч, хөтөлбөрт хамрагдсан барааны инфляцийг огцом бууруулаад байна (Зураг 1).

Зураг 1: Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрт хамрагдсан барааны инфляци болон бусад барааны инфляци (2008-2014 оны 3-р сар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Дээрх хөтөлбөрийн хүрээнд 5 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд дэд хөтөлбөр тус бүрийн хэрэгжилтэд дараах дүн шинжилгээг хийлээ.

## **ШАТАХУУНЫ ЖИЖИГЛЭНГИЙН ХУДАЛДААНЫ ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ (SIFS) ДЭД ХӨТӨЛБӨР**

### **Дэд хөтөлбөрийн шаардлага, зорилго**

Манай улсад газрын тосны бүтээгдэхүүний борлуулалтын үнийн инфляцид үзүүлэх шууд болон шууд бус нөлөөлөл хүчтэй байдаг тул шатахууны үнийг тогтвортой байлгах асуудал нь төгрөгийн тогтвортой байдал буюу үнийн тогтвортой байдлыг хангах Монголбанкны үндсэн зорилттой шууд хамааралтай юм.

Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортой байлгахын тулд Засгийн газраас нефть боловсруулах үйлдвэр байгуулах, улсын нөөц бүрдүүлэх зэрэг дунд болон урт хугацаанд хэрэгжих ажлуудыг гүйцэтгэхээр ажиллаж байна. Гэхдээ эдгээр ажлууд хийгдэх хүртэл жижиглэнгийн шатахууны үнийн өсөлтийг аль болох бага, тогтвортой түвшинд байлгахын тулд шатахууны импортын санхүүжилтийн өртгийг багасгах, валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарах нөлөөллийг бууруулах зэрэг богино хугацааны арга хэрэгслүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай гарсан.

Иймд, дээрх шаардлага, зорилтыг хэрэгжүүлэхээр Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-171/46 дугаар хамтарсан тушаалаар “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр SIFS”-ийг батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд дараах үр дүнд хүрэхээр зорьсон.

- ✓ **Үндсэн зорилго:** Гадаад зах зээлийн нөхцөл байдалд огцом өөрчлөлт ороогүй нөхцөлд шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортой байлгана.
  - Санхүүжилтийн зардлыг бууруулна.
  - Ханшийн эрсдэлийг бууруулна.
- ✓ **Бодлогын зорилт**
  - Шатахууны импортын татварыг хилийн үнэтэй уялдуулан тогтоодог болно.
  - Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг хадгалах савыг барьсан байна.
  - Газрын тосны бүтээгдэхүүний нөөц нэмэгдсэн байна.
  - Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн эх үүсвэр төрөлжинө.


Дэд хөтөлбөрийн зорилт тус бүрт 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар дүн шинжилгээ хийвэл хэрэгжилт нь дараах байдалтай байна.

### **✓ Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах зорилгын хүрээнд**


Хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд: (i) гадаад үнийг газрын тосны олон улсын биржийн үнэд суурилан тооцдог болсон, (ii) шатахуун импортлогч компаниудын эргэлтийн хөрөнгийн дутагдал, валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан үнэ өсөх эрсдэлийг бууруулсан зэргээс шалтгаалж түлш шатахууны үнийн тогтвортой байдлыг хангасан.

Хөтөлбөр эхлэхээс өмнө /2010-2012 он/ шатахууны жижиглэнгийн үнэ дунджаар 100-200 төгрөгөөр нэмэгдэж байсан бол 2013-2014 онд жилд дунджаар 50 төгрөгөөр буурч, 40-50 төгрөгөөр өссөн буюу зөрүү 10 төгрөгөөр буурсан.

Зураг 2: А-92 шатахууны жижиглэнгийн худалдааны үнийн сарын өөрчлөлт (төгрөгөөр)



Зураг 3: Дизель түлшний жижиглэнгийн худалдааны үнийн сарын өөрчлөлт (төгрөгөөр)



Эх сурвалж: Уул уурхайн яам, Газрын тосны газар

### ✓ Санхүүжилтийн зардлыг бууруулах зорилтын хүрээнд

Хүснэгт 1: Дэд хөтөлбөрийн болон банкны зээлийн нөхцөлийн харьцуулалт

тэрбум төгрөгөөр

Зээлийн нөхцөл	Санхүүжилт	Жигнэсэн дундаж хуу	Хүүгийн зардал	
			Нийт	Литр**
Банкны нөхцөл*	177.5	14.9%	26.4	36.8
SIFS-ийн нөхцөл	177.5	3.8%	6.7	9.4
<b>Зөрүү /хэмнэлт/</b>		<b>4х</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>

\* Дэд хөтөлбөр эхлэхийн өмнөх нефтийн компаниудын банкуудаас авсан зээлийн нөхцөл

\*\* 2013 оны жижиглэнгийн борлуулалтын дүнд үндэслэн тооцов.

Хүснэгт 2: SIFS дэд хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн мэдээ

тэрбум төгрөгөөр

№	ААН	Олгосон*			Эргэн тэлсэн	
		2012-2013	2014	Нийт	5/30/2014	5/30/2014
1	НИК ХХК	57.4		57.4	11.5	45.9
2	Петростар ХХК		24.0	24.0	0.0	24.0
3	Магнай трейд	42.5		42.5	8.5	34.0
4	Шунхлай ХХК	35.3		35.3	7.1	28.2
5	Сод Монгол	16.7	3.8	20.5	0.0	20.5
6	Жаст Ойл ХХК	18.7		18.7	18.7	0.0
7	Петрожамп ХХК	1.4		1.4	0.0	1.4
8	Монпетекс ХХК	8.5		8.5	1.7	6.8
9	Ойн бирж ХХК	7.3		7.3	1.5	5.8
10	Хөрс Авто Сервис ХХК	1.0	0.5	1.4	0.0	1.4
11	Монсуль ХХК	0.3	2.8	3.1	0.0	3.1
12	Рысжан ХХК	1.0	1.1	2.1	0.0	2.1
13	Ундарга Увс ХХК	1.0	1.1	2.1	0.0	2.1
14	Синчи Ойл ХХК	1.0	1.1	2.1	0.0	2.1
	<b>Нийт</b>	<b>192.0</b>	<b>34.4</b>	<b>226.4</b>	<b>48.9</b>	<b>177.5</b>

\*- Хөтөлбөрт тусгасны дагуу санхүүжилтийн хуваарилалтыг эсил тутам шинэчилж байна

\*\*- Хөтөлбөрт заасны дагуу зээлийн гэрээг дахин 1 жилээр сунгах боломжтой.

Эх сурвалж: Монголбанк

Дэд хөтөлбөрийн хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 13 компанид хөтөлбөрт оролцогч банкуудаар дамжуулан 3.8 хувийн хүүтэй, 3 хүртэл жилийн хугацаатай /санхүүжилтийн нийт хугацаа 3 жил, зээлийн гэрээг жил тутам шинэчилж байна/ санхүүжилт олгосноос 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар олгосон нийт санхүүжилтийн үлдэгдэл **177.5** тэрбум төгрөг байна. Уг нөхцөлөөр санхүүжилт олгосноор газрын тосны бүтээгдэхүүний өртгийг литр тутамд **27** төгрөгөөр бууруулсан байна.

УИХ-ын 2013 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолын 4.1-д дэд хөтөлбөрийг зах зээлийн зарчимд шат дараатай шилжүүлэх тухай заасны дагуу 2014 онд нийт санхүүжилтийн 80%-ийг Монголбанкны эх үүсвэрээс, 20%-ийг банкууд өөрсдийн эх үүсвэрээр олгох зарчимд шилжсэн. 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 48.9 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөнөөр зээлийн үлдэгдэл 177.5 тэрбум төгрөг байна.

#### ✓ Ханшийг эрсдэлийг бууруулах зорилтын хүрээнд

Валютын ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор 2-6 сарын хугацаатай форвард хэлцлийг хөтөлбөрт оролцогч банкуудаар дамжуулан шатахууны жижиглэнгийн худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй хийж байгаа бөгөөд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш нийт **892.4** сая ам.долларын форвард хэлцлийн төлбөр тооцоо хийгдээд байна.

#### Хүснэгт 3: SIFS дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийн мэдээ

*/Хөтөлбөр эхэлснээс 2014 оны 5 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл/*

№	ААН	Төлбөр тооцоо хийгдсэн форвард			Идэвхитэй форвард		
		Сая \$	Тэрбум ₮	Ханш	Сая \$	Тэрбум ₮	Ханш
1	НИК ХХК	240.0	352.4	1 468	39.9	57.4	1 441
2	Шунхлай ХХК	206.9	299.8	1 449	18.3	26.4	1 441
3	Магнай трейд	196.9	281.3	1 429	29.5	42.5	1 441
4	Сод Монгол	89.1	130.6	1 465	17.8	25.6	1 441
5	Ойн бирж ХХК	36.3	52.9	1 455	5.1	7.3	1 441
6	Жаст ойл	31.6	44.6	1 411	-	-	-
7	Петростар	31.2	45.0	1 441	20.8	30.0	1 441
8	Монпетекс ХХК	20.0	28.6	1 428	5.9	8.5	1 441
9	Рысжан ХХК	10.4	14.8	1 432	1.8	2.6	1 441
10	Ундарга Увс ХХК	9.4	13.4	1 432	1.8	2.6	1 441
11	Монсуль ХХК	6.2	8.9	1 438	2.7	3.9	1 441
12	Синчи Ойл ХХК	5.9	8.4	1 433	1.8	2.6	1 441
13	Хөрс Авто Сервис ХХК	5.5	8.1	1 475	1.2	1.8	1 441
14	Петрожамп ХХК	2.9	4.2	1 441	1.0	1.4	1 441
<b>Нийт</b>		<b>892.4</b>	<b>1 293.1</b>	<b>1 449</b>	<b>147.6</b>	<b>212.6</b>	<b>1 441</b>

*Эх сурвалж: Монголбанк*


Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх үед форвард ханш нь Монголбанкнаас зарласан ханштай ижил түвшинд байсан бол 2013 оны 3 дугаар сараас төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларсантай холбоотойгоор зөрүү нь нэмэгдэж, 2014 оны 5 дугаар сарын байдлаар 370 төгрөгт хүрсэн байна.

#### ✓ Шатахууны биет нөөцийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд

Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 126 дүгээр тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний улсын болон компанийн нөөцийг тус бүр 30 хоног, нийтдээ 60

хоног болгон нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Уг тогтоолын үр дүнд компаниудын газрын тосны бүтээгдэхүүний нөөц дэд хөтөлбөр эхэлсэн үетэй харьцуулахад **3.1** дахин нэмэгдэж, богино хугацаанд шатахууны хомсдолд орох эрсдэлийг бууруулаад байна.

Зураг 4: Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц, сарын дундаж (мян.тн)



Эх сурвалж: Газрын тосны газар

#### ✓ Шатахууны нийлүүлэлтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх зорилтын хүрээнд

Шатахууны нийлүүлэлтийн хараат байдлыг бууруулах, гэрээний үнийг олон улсын биржийн үнэтэй нийцүүлэх зорилгоор дараах ажлуудыг авч хэрэгжүүлэв.

- БНХАУ-ын “Чайна Ойл” компанитай гэрээ байгуулж, 2013 оны 4 дүгээр сараас эхлэн сард 4-10 мянга хүртэл тонн бүтээгдэхүүн худалдан авч байна.
- БНСУ-ын компаниудтай шатахуун худалдан авах талаар хэлэлцээр хийж байгаатай холбогдуулан БНХАУ-ын “Хятадын төмөр зам” компанитай жилд 200 мянган тонн шатахууныг тус улсын нутаг дэвсгэрээр тээвэрлэх гэрээ байгуулсан бөгөөд ингэснээр БНСУ-аас импортлох шатахууны тээвэрлэлтийг шийдвэрлэсэн.
- ОХУ-ын “Роснефть”, БНХАУ-ын “Чайна Ойл” компаниудаас худалдан авдаг шатахууны үнийг газрын тосны олон улсын биржийн үнэд суурилан тооцдог боллоо. Ингэснээр нийлүүлэгч талаас шалтгаалах үнийн өсөлтийг хязгаарлах, үнийг тогтвортой байлгах, үнийн таамаглал хийх боломж бүрдсэн.
- Баянхошуу-Өвдөг боомтыг байнгын ажиллагаатай болгох, газрын тосны бүтээгдэхүүнийг Монгол Улсын зүүн, баруун бүсийн хилийн боомтуудаар нэвтрүүлэх асуудлаар холбогдох талтай хэлэлцээ хийх, хөрөнгө оруулалт, зохион байгуулалтын арга хэмжээ авах талаар Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж батлуулсан.

Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд 2012 онд **92%** байсан нийт импортод эзлэх ОХУ-ын хувийн жин дэд хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд **77%** болж **15** нэгж хувиар буурсан. Түүнчлэн Роснефть ХХК-иас авах импортын хувийн жинг 2-3 дахин бууруулж, 25 хувьд хүргээд байна.

**Хүснэгт 4: Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний импорт, гарал үүслийн орноор (хувиар)**

Импортлогч улс	Огноо		Зөрүү %
	2012	2013-2014.05	
БНСУ	2%	7%	↑ 5%
БНХАУ	0%	4%	↑ 4%
Литва	1%	1%	↑ 0%
<b>ОХУ</b>	<b>92%</b>	<b>77%</b>	<b>↓ -15%</b>
Бусад	6%	11%	↑ 6%

Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

✓ **Татварын зохицуулалтыг сэргээх зорилтын хүрээнд**

Шатахууны импортын татварыг хилийн үнийн бууралттай уялдуулан сэргээж, татварын зохицуулалтын орон зайг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2012 оны 10 сар, 2013 оны 7 сар тус тус газрын тосны бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварыг нэмэгдүүлсэн бол хилийн үнийн өөрчлөлт, төгрөгийн ханш суларсантай уялдуулан 2013 оны 12 сар, 2014 оны 1 сард татварын хэмжээнд өөрчлөлт оруулсан.

**Хүснэгт 5: Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний импортод ногдуулж буй татвар**

	Онцгой албан татвар		Гаалийн татвар	Тогтоол огноо, дугаар
	Уул уурхай	Бусад салбар		
<b>2012 оны 9 сар</b>				
АИ80	0 ₮/тн	0 ₮/тн	-	
АИ92				
Дизель				
<b>2012 он 11 сар</b>				
АИ80	130,000 ₮/тн	0 ₮/тн	-	Засгийн газрын 2012.12.23-ны өдрийн 134 дүгээр тогтоол
АИ92	0 ₮/тн	0 ₮/тн		
Дизель	109,000 ₮/тн	0 ₮/тн		
<b>2013 он 7 сар</b>				
АИ80	130,000 ₮/тн	0 ₮/тн	Хилийн үнийн 3%	Засгийн газрын 2013.07.06-ны өдрийн 236 дугаар тогтоол
АИ92	0 ₮/тн	0 ₮/тн		
Дизель	109,000 ₮/тн	80,000 ₮/тн		
<b>2013 он 12 сар</b>				
АИ80	130,000 ₮/тн	0 ₮/тн	Хилийн үнийн 3%	Засгийн газрын 2013.12.07-ны өдрийн 406 дугаар тогтоол
АИ92	0 ₮/тн	0 ₮/тн		
Дизель	109,000 ₮/тн	0 ₮/тн		
<b>2014 он 1 сар</b>				
АИ80	30,000 ₮/тн	30,000 ₮/тн	Хилийн үнийн 1%	Засгийн газрын 2014.01.28-ны өдрийн 24 дүгээр тогтоол
АИ92	0 ₮/тн	0 ₮/тн		
Дизель	30,000 ₮/тн	30,000 ₮/тн		

Эх сурвалж: www.legalinfo.mn

✓ **Роснефть компанитай хийж буй яриа хэлэлцээрийн талаар**

Монгол Улсын Газрын тосны газар ОХУ-ын газрын тосны Роснефть компанитай 2014 оны 5 дугаар сарын 23-ний өдөр байгуулсан гэрээ нь дараах үр дүнд хүргэхээр байна.

**Хүснэгт 6: Роснефть ХХК-тай хийж буй хэлэлцээрээс хүлээгдэж буй үр дүн**

Үзүүлэлт	Одоогийн нөхцөл байдал	Гэрээгээр өөрчилсөн	Нөлөөлөл
Хилийн үнэ	Италийн биржийн үнэ	Сингапурын биржийн үнэ	<b>Эерэг</b> - Хилийн үнэ тонн тутамдаа 50\$-оор буурах, - Үнэ хэлбэлзэх эрсдэл буурах
Худалдах нөхцөл	Урьдчилгаа <b>50%</b> /өмнөх сарын 20-ны өдөр/, дараагийн төлбөр <b>50%</b> /тухайн сарын 10-ны дотор/	Төлбөрөө бүтээгдэхүүн ачуулснаас хойш <b>30</b> хоногийн дотор шилжүүлэх	<b>Эерэг</b> - Төлбөрийн тааламжтай нөхцөл, - Борлуулалтын орлогоороо төлбөрөө төлөх
Импортын хэмжээ		5 жилийн хугацаанд 2 тэрбум ам.долларын бүтээгдэхүүн авна	<b>Эерэг</b> - Нийлүүлэлтийн тасралтгүй байдал хангагдах,
Сарын дундаж импорт	2014 оны эхний сарын байдлаар 20 мянган тонн /нийт импорт <b>25%</b> /	Сард 60 мянган болон түүнээс дээш тонн /нийт импорт <b>80%</b> /	<b>Сөрөг</b> - Роснефтээс хараат байдал нэмэгдэх, - Хөтөлбөрийн бодлогын зорилт зөрчигдөх

Эх сурвалж: Газрын тосны газар, [www.rosneft.com](http://www.rosneft.com)

Роснефть ХХК-тай гэрээ байгуулснаар газрын тосны бүтээгдэхүүний импортын үнэ тонн тутамд ойролцоогоор 50 ам.доллараар буурах, борлуулалтын орлогоороо импортын төлбөрөө төлөх нөхцөл бүрдэх, төгрөгийн зээл авах шаардлага багасах зэрэг эерэг нөлөөтэй байгаа хэдий ч, сард дунджаар 60 мянган тонноос дээш бүтээгдэхүүн заавал авахаар болсон нь дэд хөтөлбөрийн хүрээнд амжилттай хэрэгжсэн шатахууны нийлүүлэлтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх зорилтод харшилж болзошгүй юм.

**Хэрэгжээгүй буюу хугацаа хойшлогдсон ажлууд**

Дэд хөтөлбөрт тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилт хангалтгүй байгаа нь хөтөлбөрийн эцсийн үр дүнд нөлөөлж байна.

**Хүснэгт 7: Бүрэн хэрэгжээгүй, хэрэгжилтийн шатандаа байгаа ажлууд**

№	Ажил	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжилтийн явц
1	Шатахууны жижиглэнгийн худалдааны өртгийг тооцоолох аргачлалыг батлах	2013 он	<b>Хугацаа хойшлогдсон.</b> Хамтарсан шалгалтын дүгнэлт гарсны дараа боловсруулах
2	Үнэ бүрдэлтийг батлагдсан хүснэгтийн дагуу УУЯ, ГТГ-ын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй болгох	2014 оны 1 дүгээр сараас эхлэн	<b>Хэрэгжээгүй.</b> 2014 оны 3 дугаар сард үнэ бүрдэлтийг УУЯ, ГТГ-ын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн хэдий ч, 4, 5 дугаар сард мэдээлээгүй.
3	Дэд хөтөлбөрийн хамтарсан шалгалтыг 2014 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулах, шалгалтын үр дүнд үндэслэн жижиглэнгийн	2014 оны 2 дугаар улирал	<b>Хэрэгжилтийн шатандаа.</b> Хамтарсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Шалгалтын үр дүнг 2014 оны 2



	худалдааны мэдээ гаргах журмыг батлан мөрдүүлэх		дугаар улиралд багтаан танилцуулна.
4	Уул уурхайн яам нь Сангийн яамтай хамтран шатахууны хилийн үнийн өсөлт, ханшийн өөрчлөлтийг борлуулалтын үнэд шингээх аргачлалыг боловсруулж, Засгийн газрын тогтоолоор батлуулах	2014 оны 2 дугаар улирал	<b>Хэрэгжилтийн шатандаа.</b> Сангийн яамны төсвийн орлогын хэлтсийн зүгээс аргачлалыг эхний байдлаар бэлтгэн гаргаад байгаа.
5	Шатахууны хилийн үнийн өөрчлөлттэй уялдуулан татварын зохицуулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах	2014 оны 2 дугаар улирал	<b>Хэрэгжилтийн шатандаа.</b> УУЯ-наас тооцоо, судалгаа хийж байна.
6	Шатахууны өртгийн өөрчлөлттэй уялдуулан санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийн ханшийг өөрчлөн тооцох	2014 оны 2 дугаар улирал	<b>Хэрэгжилтийн шатандаа.</b> Хамтарсан шалгалтын дүгнэлт гарсны дараа боловсруулах

Эх сурвалж: Монголбанк, Уул уурхайн яамны хамтарсан үнэлгээ

### **Дэд хөтөлбөрт тавих хяналт, ил тод, нээлттэй байдал**

#### **Тогтмол хяналт, мэдээллийн ил тод байдал:**

- Дэд хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн эрсдэлийг оролцогч банк хариуцахаар гэрээнд тусгасан тул банкууд хэрэгжүүлэгч компаниудад зээл олгохдоо бусад арилжааны зээлтэй адил зарчмыг баримталж байна. Өөрөөр хэлбэл зээлдэгчийн санхүүгийн мэдээлэл, зээлийн эрсдэлийг судалж үзсэний үндсэн дээр хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг барьцаалж зээлийн гэрээ байгуулж байгаа бөгөөд банкуудаас Монголбанкинд зээлийн мэдээллийг тогтмол ирүүлж байна.
- Оролцогч банк нь дэд хөтөлбөрийн санхүүжилт, санхүүгийн үүсмэл хэрэгслийн зарцуулалтын тайланг сар бүр, компанийн санхүүгийн тайланд хийсэн дүн шинжилгээг улирал бүр Монголбанкинд ирүүлж байна.
- Хэрэгжүүлэгч компани нь дэд хөтөлбөрийн хүрээнд байгуулсан гэрээний дагуу шатахууны нөөцийн мэдээг 7 хоног тутам, жижиглэнгийн болон бөөний борлуулалтын мэдээг сар тутам Газрын тосны газарт хүргүүлж байна.
- Монголбанк, Уул уурхайн яам хамтран дэд хөтөлбөрийн үр дүн, зорилтот ажлуудын биелэлтийг улирал тутам дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх асуудлуудыг тодорхойлж байгаа бөгөөд үнэлгээг Монголбанкны цахим хуудаст тухай бүр байршуулан, олон нийтэд мэдээлж байна.

#### **Дэд хөтөлбөрийн шалгалт:**

Дэд хөтөлбөрт тусгагдсаны дагуу Монголбанк, Уул уурхайн яам, Газрын тосны газар хамтран дэд хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавьж байгаа бөгөөд хөтөлбөр хэрэгжих хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

- Газрын тосны газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг Газрын тосны газраас хэрэгжүүлэгч компаниудтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хийх шалгалтыг 2013 оны 8 дугаар сарын 20-ноос 9 дүгээр сарын 6-ны өдрүүдэд зохион байгуулсан.

- Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар байгуулагдсан шалгалтын ажлын хэсэг дэд хөтөлбөрүүдийн хүрээнд олгосон зээлийн үйл ажиллагаанд 2013 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 25-ны өдрийн хооронд оролцогч банкууд дээр газар дээрх шалгалтыг зохион байгуулсан. Түүнчлэн, Монголбанкнаас 2013 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Хадгаламж банкны Байгууллагын банкны газарт баримтын шалгалтыг хийсэн болно.
- Уул, уурхайн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсэг байгуулагдан, 2014 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс 5 дугаар сарын 30-ны хооронд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 13 компани дээр шалгалтаар ажиллаж байна.

### Дүгнэлт, санал

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах эерэг үр дүн гарсан. Үүнд:

- Хөтөлбөр эхэлсэн үетэй харьцуулахад төгрөгийн ам.доллартай харьцах ханш 30 хувиар сулрахад жижиглэнгийн үнэ 5 хувиар өссөн буюу маш тогтвортой байсан,
- Хэрэгжүүлэгч компаниудад жилийн 3.8 хувийн хүүтэй зээл олгож, ханшийн эрсдэлийг бууруулснаар санхүүжилтийн өртгийг бууруулсан,
- Хөтөлбөр эхэлснээс хойш компаниудын биет нөөц 3 дахин нэмэгдэж, богино хугацаанд шатахууны хомсдолд орох эрсдэл эрс буурсан,
- Шатахууны импортын эх үүсвэрийг төрөлжүүлснээр нийлүүлэлтийн тасралтгүй байдал эрс сайжирч, хилийн үнэ буурах нөхцөл бүрдсэн,
- Импортын татварыг хилийн үнийн өсөлт, бууралттай уялдуулан өөрчилдөг болсноор татварын зохицуулалтыг сэргээсэн,
- Хөтөлбөрт тогтмол хяналт тавьж байгаагаас зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу хийгдэж байна.

SIFS дэд хөтөлбөр нь дээр дурсан үр дүнд хүрсэн хэдий ч, хөтөлбөрийн форвард ханш, зах зээлийн ханшаас хэт зөрүүтэй байгаагаас шалтгаалан хөтөлбөр хэрэгжиж дуусах үед жижиглэнгийн үнэ нэмэгдэх эрсдэлтэй гэж үзэж байна. Иймд, эрсдэлийг бууруулах, хөтөлбөрийн үр дүнг сайжруулахын тулд дараах ажлуудыг хэрэгжүүлэх саналтай байна.

- Дэд хөтөлбөр болон Роснефть компанитай байгуулсан гэрээний үр дүнд хилийн үнэ буурахаар байгааг харгалзан хөтөлбөр дуусах хүртэлх хугацаанд шинээр нэмж хийх форвард хэлцлийн ханшийг спот ханштай уялдуулан шинэчлэн тогтоох,
- Импортын шатахууны төлбөрийг 30 хоногийн дараа төлөх нөхцөл бүрдсэн тул дэд хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийг эргүүлэн төлүүлж, шинээр зээл олгохгүй байх,
- Хилийн үнэ буурах эерэг хандлага гарч байгаатай уялдан татварын зохицуулалтыг ашиглан шатахууны нөөцийг тогтвортой өндөр түвшинд байлгах,
- Шатахууны жижиглэнгийн худалдааны үнэд хилийн үнийн бууралт, ханшийг зах зээлийн нөхцөлөөр тооцохтой холбоотойгоор гарах өөрчлөлтийг үе шаттайгаар, алгуурхан шингээх,
- Хэрэгжээгүй, хугацаа хойшилсон байгаа ажлуудыг 2014 оны 2 дугаар улиралд багтаан бүрэн гүйцэтгэх.

\_\_\_ооо\_\_\_

## ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ ИМПОРТЫН БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТГИЙГ БУУРУУЛАХ (TLF) ДЭД ХӨТӨЛБӨР

### Дэд хөтөлбөрийн шаардлага, зорилго

Монгол Улс өргөн хэрэглээний бүтээгдэхүүний хэрэгцээний тодорхой хэсгийг импортоор хангаж байгаа өнөөгийн нөхцөлд гадаад худалдааны тээвэр, логистикийн өндөр зардал, хүчин чадлын дутагдалтай байдал нь бүтээгдэхүүний үнийг өсгөх, нийлүүлэлтийн хомсдолыг үүсгэх замаар инфляцид сөргөөр нөлөөлж ирсэн. Иймд өргөн хэрэглээний импортын бүтээгдэхүүний нийлүүлэлтийн жигд, тасралтгүй байдлыг хангах, үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор гадаад худалдааны тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулах шаардлагатай болсон.

Дээрх шаардлага, зорилгыг хэрэгжүүлэхээр Монголбанкны Ерөнхийлөгч, Зам, тээврийн сайдын 2012.10.26-ны өдрийн А-167/57 дугаар хамтарсан тушаалаар “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна.

Энэхүү хөтөлбөр (TLF) нь 3 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд төмөр замын үйлчилгээг сайжруулах, хөнгөвчлөх зорилгоор гадаад, дотоод харилцааны бодлого төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын шат дараалсан ажлуудыг хэрэгжүүлэхийн сацуу нийт 303 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн эх үүсвэрийг хамтарсан тушаалаар баталсан ажлуудыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

### Зорилтын хүрээнд хийгдсэн ажил, хүрсэн үр дүн

Хамтарсан тушаалын дагуу дэд хөтөлбөрийн зорилтот ажлын хэрэгжилтийг улирал бүр дүгнэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлсон бөгөөд энэ талаарх мэдээллийг Монголбанкны цахим хуудаст тогтмол байршуулж ирлээ.

### Зорилт 1: Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний ачаа эргэлтийг нэмэгдүүлж хурдасгана (Замын Үүд - УБ чиглэл).

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүн	Биелэлт
<ul style="list-style-type: none"> <li>• Тусгай зориулалтын 2 галт тэргийг хатуу зурмагаар аялуулах.</li> <li>• Сэлгээний ажил болон ачаа ачиж, буулгах үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулан хурдасгах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн (ӨХББ)-ий тээвэрлэлтэд зориулан өдөрт 100-гаас доошгүй вагоноор хангаж, 9000 тонн ачааг <u>Замын Үүд</u> - УБ хооронд 24 цагийн дотор тээвэрлэх.</li> </ul>	<p><b>Биелэлт САЙН</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• <u>ӨХББ</u>-ий тээвэрлэлтийг 2012.10.29-ний өдрөөс эхлэн тогтсон хуваарийн дагуу тусгайлсан 2 галт тэргээр, 3 дахь галт тэргийг 2013 оны 4-р сараас, 4 дэх галт тэргийг 2014 оны 4-р сараас тус тус гүйцэтгэж, нийт 1432 галт тэрэг, 85 мянган вагоноор 2.9 сая тонн ачаа тээвэрлэсэн.</li> <li>• <u>ӨХББ</u>-ийг <u>Замын Үүд</u> - УБ хооронд 21 цагт багтаан тээвэрлэлт хийж байна.</li> <li>• Ачилт, сэлгээний ажлыг тусгай журмаар зохицуулснаар технологийн цаг 24 байсныг 11 цаг болгон бууруулж, вагон эргэлтийн хугацаа 2013 оны 1-р сард 3.56 хоног байсныг 2.83 хоног болгон хурдасгасан.</li> </ul>

**Зорилт 2: Ачаа тээвэрлэлтийн өртгийг бууруулах.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүн	Биелэлт
<ul style="list-style-type: none"> <li>• Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн өртгийг бууруулах.</li> <li>• Монгол-Орос ХНН УБТЗ-ын шатахууны эргэлтийн хөрөнгөд зориулан зээл олгох.</li> <li>• Тарифын бус зардлыг бууруулахад чиглэсэн зохион байгуулалт, хяналтыг сайжруулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ачаа тээвэрлэлтийн өртөг буурсан байх.</li> <li>• Шатахууны зардал 17% хүртэл буурах. (22 хүртэл тэрбум төгрөгийн зээл олгох)</li> <li>• Холбогдох байгууллагуудтай хамтран арга хэмжээ авсан байх.</li> </ul>	<p><b>Биелэлт САЙН</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төмөр замын тээврийн тухай хуулийн 7.1-д тусгаснаар төмөр замын тээвэрлэлтийн тарифын өөрчлөлтийг ШӨХТГ-ын даргын тогтоолоор шийдвэрлэж, УБТЗ нийгэмлэгийн Замын даргын тушаал гарч нийтээр мөрддөг ба ӨХББ-ий тээвэрлэлтийн өртөг нь 2011.09-р сараас хойш өөрчлөгдөөгүй тогтвортой байна.</li> <li>• УБТЗ-ын шатахууны эргэлтийн хөрөнгөд нийт 22 тэрбум төгрөгийн зээлийг олгосон ба зээл хуваарийн дагуу эргэн төлөгдсөөр үлдэгдэл нь 10.2 тэрбум төгрөг байна. Зээл нь шатахууны зардалд 4 тэрбум төгрөгийн хэмнэлт бий болгосноор ачаа тээвэрлэлтийн өртөг нэмэгдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн.</li> <li>• Нэг цэгийн үйлчилгээг бий болгох, цаасгүй технологийг нэвтрүүлэх, үйлчилгээг түргэн шуурхай болгох зорилгоор Замын Үүдийн Шилжүүлэн ачих ангид ачаа тээврийн программ, автомашины дарааллыг хянах программ суурилуулснаар нэг машинд зарцуулах хугацаа 20 минут байсныг 1 минут болгож бууруулсан.</li> <li>• Тарифын бус зардлыг бууруулахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалт, хяналтын тодорхой ажлуудыг гүйцэтгэж, “УБТЗ” нийгэмлэгийн бүтцийг шинэчлэх талаар санал боловсруулах Ажлын хэсгийг Зам, тээврийн сайдын тушаалаар байгуулан ажиллаж байна.</li> </ul>

**Зорилт 3: Тяньжин-Замын-Үүд чиглэлийн ачаа тээвэрлэлтийг хөнгөвчилнө.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүн	Биелэлт
<ul style="list-style-type: none"> <li>• Тяньжин боомтын шилжүүлэн ачилт болон бусад үйл ажиллагааг хурдасгах.</li> <li>• Ачаа тээвэрлэлтийн хугацааг багасгах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Зам, тээврийн яамнаас холбогдох арга хэмжээг авсан байх.</li> </ul>	<p><b>Биелэлт ДУНД</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Нарийн царигийн төмөр замаар ирж байгаа вагонуудыг шуурхай хүлээн авч шилжүүлэн ачих ажлыг 2012.11 сараас тогтмол зохион байгуулснаар Хятадын төмөр зам, Тяньжин боомтод ачааны саатал гараагүй.</li> <li>• 2013.05.20-23-ны өдрүүдэд Бээжин хотноо болсон Монгол, Хятадын ЗГ хоорондын комиссын XIII хуралдаанаар Монголын тал Замын Үүд-Тяньжин чиглэлийн чингэлгийн буухиа галт тэрэг аялуулах, Хятад-Монголын хилийн өртөө хооронд галт тэрэг ойртолтын мэдээ солилцох саналыг Хятадын талд тавьсан. Улмаар "УБТЗ" нийгэмлэг БНХАУ-ын төмөр замын талаас тавьсан шаардлагыг бүрэн</li> </ul>

		<p>хангасан бөгөөд одоо БНХАУ-ын талын шийдвэрийг хүлээж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Далайд гарах боломжийг нэмэгдүүлэх талаар ЗГ-ын 2013 оны 152 дугаар тогтоолд БНХАУ-ын <u>Тяньжин хотын Бинхай</u> шинэ дүүрэгт “<u>Дунзяны гаалийн баталгаат боомт</u>” бүсэд Хятадын талтай хамтарсан “<u>Тяньжин-Монголын тээвэр логистикийн төв</u>” төслийг хэрэгжүүлэх Монголын талын төлөөллөөр “Монголын төмөр зам” ТӨХК-ийг давуу эрхээр оролцуулахаар шийдвэрлэсэн. Төслийн нарийвчилсан <u>ТЭЗҮ-г Тяньжин хотын барилгын зураг төслийн хүрээлэнгээр хийлгэхээр Тяньжин порт групптэй 2013.12 сард гэрээ байгуулан ажиллаж байна.</u></li> </ul>
--	--	--

**Зорилт 4: Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүн	Биелэлт
<ul style="list-style-type: none"> <li>• Төмөр замын салбарын ачааны вагон паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.</li> <li>• Монгол-Оросын хувь нийлүүлсэн УБТЗ нийгэмлэгийн зүтгүүрийн паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• 1000 вагоноор нэмэгдсэн байх. <b>(136 хүртэл тэрбум төгрөгийн зээл олгох)</b></li> <li>• 20 зүтгүүрээр нэмэгдсэн байх. <b>(95 хүртэл тэрбум төгрөгийн зээл олгох)</b></li> </ul>	<p><b>Биелэлт ДУНД</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• УБТЗ ХНН өөрийн хөрөнгөөр /дүрмийн санг нэмэгдүүлсэн хөрөнгө/ 2013 оны 9-р сард 3 ширхэг Загал зүтгүүр угсарч, <u>ашиглалтад оруулсан</u>. Мөн сэлгээний 4 зүтгүүр худалдан авсан. Түүнчлэн, 2014 оны 5-р сард 15 зорчигчийн вагон, төмөр замаар явагч автобус буюу railbus худалдан авч вагон паркийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн.</li> <li>• УБТЗ ХНН-ийн Ерөнхий хорооны 2013.05.08-ны өдрийн хурлаар ачааны 460 вагон, 6 зүтгүүрийг 70.7 тэрбум төгрөгөөр худалдан авахаар шийдвэрлэсэн. УБТЗ ХНН-ээс 2014 оны 5-р сард зээл эргэн төлөх хугацааг 5 жил болгон сунгах хүсэлтийг ЗТЯ болон Монголбанкинд ирүүлээд байна.</li> <li>• Мөн ЗТЯ-наас 2014 оны 5-р сард “Зүтгүүр угсралтын үйлдвэр байгуулах” төслийг хэрэгжүүлэхэд 19 тэрбум төгрөгийн зээлийг 5 жилийн хугацаатай олгуулах тухай саналыг Монголбанкинд ирүүлээд байна.</li> </ul>

**Зорилт 5: Ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүн	Биелэлт
<p>•Замын Үүд боомтын төмөр зам, авто замын ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэх.</p> <p>•Улаанбаатар хот дахь ачааны терминалын ачаа боловсруулах чадварыг нэмэгдүүлэх.</p>	<p>•УБ, Замын Үүдийн төмөр зам, авто замын ачаа тээврийн нэгдсэн терминалыг батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу өргөтгөсөн байх (50 хүртэл тэрбум төгрөгийн зээл олгоно)</p> <p>•Замын Үүдийн Улсын хилийг терминал 3-тай холбосон авто замыг ашиглалтад оруулсан байх.</p>	<p><b>Биелэлт ДУНД.</b></p> <p>• “Замын Үүдийн логистикийн төвийн шилжүүлэн ачих битүү болон дээвэр бүхий задгай агуулах барих төсөл”-ийн гүйцэтгэгчээр шалгарсан “Ай Би <u>Эй Логистикс</u>” ХХК-д 2014.05.13-ны өдөр 20 тэрбум төгрөгийн зээлийг олгосон ба зээлийн баримт бичгийн бүрдлийг үндэслэн дахин 30 тэрбум төгрөгийг олгоно.</p> <p>• “Замын-Үүд хилийн боомтын ачааны автомашин шалган нэвтрүүлэх цогцолбор-Гаалийн рентген хяналтын талбай-Замын-Үүдийн шилжүүлэн ачих III терминал” хооронд хүнд даацын 11 км урт, хатуу хучилттай авто замыг Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр барьж, ашиглалтад оруулан ажиллаж байна.</p>

**Дүгнэлт, санал**

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний ачаа эргэлт нэмэгдэж, тээвэрлэлтийн хугацаа богиносж, вагон эргэлт хурдасч, тээвэрлэлтийн үйлчилгээ түргэн шуурхай болсон. Энэ нь ЗТЯ болон УБТЗ-ын удирдлага зохион байгуулалтын ажлын үр дүн бөгөөд цаашид ч тусгай зориулалтын галт тэрэг аялуулах ажлыг үргэлжлүүлж, ачаа эргэлтийг улам хурдасган ажиллахаар төлөвлөж байна.

Дэд хөтөлбөрт 303 тэрбум төгрөгийн зээл олгохоор баталсан хэдий ч, өнгөрсөн 1 жил 7 сарын хугацаанд УБТЗ ХНН-д 22 тэрбум төгрөг, “Ай Би Эй Логистикс” ХХК-д 20 тэрбум төгрөг, нийт 42 тэрбум төгрөг буюу 13%-ийг л олгоод байна.

Цаашид энэхүү дэд хөтөлбөрийн хүрээнд нэмж зээл олгохооргүй байна гэж Монголбанкнаас үзсэн. Энэ нь зам тээврийн салбарт зайлшгүй хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудыг улсын төсөв, Засгийн газрын бусад эх үүсвэр, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой.

— ооо —

## ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ (FPS) ДЭД ХӨТӨЛБӨР

### ○ МАХНЫ НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ, ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨР

#### Хөтөлбөрийн хэрэгжилт

Махны нөөц бүрдүүлэх үнийг тогтворжуулах хөтөлбөрийг 2 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна.

**2013 онд:** Дэд хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хэрэгцээнд зориулан нөөцийн махны менежер “Жаст Агро” ХХК, “Эрдмийт” ХХК, “Баатрууд тэнгэр” ХХК-иуд нийт 11,461.8 тонн махны нөөцийг 87 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр бэлтгэн, худалдан борлуулах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Зээлийн эх үүсвэр бүрэн төлөгдөж, нөөцийн махыг борлуулж дууссан. Хөтөлбөрийн дагуу нөөцийн мах борлуулж байсан хугацааны туршид махны жижиглэн худалдаалах үнийн хэлбэлзэл (жилийн дундаж өсөлтөөр тооцов) өмнөх 3 жилийн дунджаас 3.1 дахин бага байжээ.

**2014 онд:** Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад “Баатрууд тэнгэр” ХХК 6001.6 тонн, “Эй Эн Ди Эм” ХХК 6560.3 тонн, “Дархан мийтфүүд” ХХК 1000.0 тонн, “Эрдмийт” ХХК 1001.5 тонн нөөцийн мах бэлтгэн, сертификатаар баталгаажуулан борлуулж байна. УИХ-ын 2013 оны 11 сарын 14-ний 62 дугаар тогтоолын 4.1-д заасны дагуу хөтөлбөрийг зах зээлийн механизмд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлэх зорилгоор хөтөлбөрийн зээлийн 20%-ийг банкны өөрийн эх үүсвэрээр, 80%-ийг Монголбанкны эх үүсвэрээр санхүүжүүлэв. Хөтөлбөрийн хүрээнд банкууд нөөцийн менежер компаниудад 77 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов. Нөөцийн махны менежерүүд хонины мах 6500.0 тонн (44.6 хувь), ямааны мах 3276.5 тонн (22.5 хувь), үхрийн мах 4787.0 тонн (32.9 хувь), нийт 14,546.4 тонн мах бэлтгэлээ.

Нөөцийн махны худалдааг 2013 оны 12-р сарын 25-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, 2014 оны 5-р сарын 16-ны өдрийн байдлаар 7,322.5 тонн (нийт бэлтгэсэн махны 50.3 хувь) махыг борлуулж, хуваарийн дагуу 29.8 тэрбум төгрөгийн зээлийг буцаан төлөөд байна. Энэ хугацаанд махны жижиглэн худалдаалах үнийн хэлбэлзэл (жилийн дундаж өсөлтөөр тооцов) өнгөрсөн оноос 1.7 дахин бага, хөтөлбөр хэрэгжүүлэхээс өмнөх 3 жилийн дунджаас 5.3 дахин бага байна.

#### Өмнөх жилээс ялгарах онцлог

- Хүн амын 2013 оны хэрэгцээнд зориулж УБ хотын жилийн нийт махны хэрэгцээний 15.4%-ийг бүрдүүлсэн бол 2014 онд 16.2%-ийг бүрдүүлээд байна. Түүнчлэн 2013 онд 16 мянган тонн мах бэлтгэхээр төлөвлөж, түүний 71.6%-ийг бүрдүүлсэн бол 2014 оны 14 мянган тонн мах бэлтгэхээр төлөвлөж, 104%-иар бэлтгэлээ.
- 2013 онд махны нөөц бэлтгэх, худалдан борлуулах явцад Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Онцгой байдлыг ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон Төрийн бус байгууллагууд хяналт тавьж ажилласан. Харин энэ жилийн хяналтын тогтолцооны ялгаатай тал нь нөөцийн менежер тус бүр дээр зээл олгосон банкуудаас байнгын бөгөөд давхар хяналт тавьж ажиллаж байна. Ингэснээр цаашид Засгийн газар болон Монголбанкны оролцоогүйгээр махны нөөц бэлтгэлийн ажил үргэлжлэх, хяналтын болон бусад үйл ажиллагаа нь зөвхөн хувийн хэвшлийн оролцоотойгоор тогтмолжих боломж бүрдэнэ.

- Түүнчлэн 2013 онд бэлтгэсэн нөөцийг 100 хувь Монголбанкнаас банкинд олгосон зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж байсан бол 2014 онд 80%-ийг нь Монголбанкнаас банкинд олгосон зээлээр санхүүжүүлж, үлдсэн 20%-ийг банкууд өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна. Цаашид дэд хөтөлбөрийн санхүүжилт дэх Монголбанкны зээлийн эх үүсвэрийн эзлэх хувь хэмжээ буурах, банкуудын өөрийн эх үүсвэрээр олгох хувь хэмжээ нь өсөн нэмэгдэх зохицуулалт үйлчлэх бөгөөд дунд хугацаанд Монголбанк хөтөлбөрөөс гарах төлөвлөгөөтэй ажиллаж байна.


### Хөтөлбөрийн үр дүн зорилттой нийцтэй эсэх

Монголбанк болон ҮХААЯ хамтран 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдөр А-166/А/24 дугаар тушаалаар баталсан дэд хөтөлбөрт дараах зорилтыг тавин ажиллаж байна. Үүнд:

**Ойрын зорилго:** Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах.


Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн 2013 онд махны жилийн дундаж өсөлт нь 10.5%, 2014 оны эхний 4 сард 6.2% байсан. Энэ нь өмнөх 2010-2012 оны жилийн дундаж өсөлттэй харьцуулахад харгалзан 3.1 болон 5.3 дахин бага байна.

Зураг 5: Махны үнийн жилийн дундаж өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 6: Инфляцийн задаргаа




2010-2012 оны дунджаар УБ хотын жилийн инфляцийн 3.6%-ийг махны үнийн өсөлт тодорхойлдог байсан бол 2013 онд дунджаар 1.9%, 2014 оны эхний 4 сарын байдлаар 0.9% болж буураад байна. Эдгээрээс дүгнэхэд дэд хөтөлбөр нь ойрын зорилгодоо хүрсэн гэж үзэж байна.

**Хэтийн зорилго:** Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2013 оны 62 дугаар тогтоол, дэд хөтөлбөрийн 1.2 дахь заалтад заасны дагуу хүнсний бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэн, хүнсний бараа, бүтээгдэхүүний хангамжийн зах зээлд суурилсан байнгын тогтолцоог бүрдүүлэх.


2013 онд хүн амын хэрэгцээнд зориулж УБ хотын жилийн нийт махны хэрэгцээний 15.4%-ийг бүрдүүлсэн бол 2014 онд 16.2%-ийг бүрдүүлсэн. Үүний 13 нэгж хувийг нь Монголбанкнаас банкинд олгосон зээлийн санхүүжилтээр, үлдсэн 3.2 нэгж хувийг нь банкнаас өөрийн эх үүсвэрээр олгосон зээлээр бэлтгэсэн байна. Ийнхүү агуулах дахь хөдлөх хөрөнгийн нөөцийг санхүүжүүлэх санхүүгийн шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтэрсэн бөгөөд дунд хугацаанд санхүүжилтийн эх үүсвэрийг 100 хувь хувийн хэвшил дангаар шийдвэрлэх тогтолцоонд шилжих юм. Түүнчлэн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, махны нөөц бэлтгэл болон борлуулалтын үйл ажиллагаанд хяналтын байгууллагуудаас гадна хөтөлбөрт оролцогч банкнаас тогтмол хяналт тавин ажиллаж байна.



Зураг 7: Махны нөөц / УБ хотын жилийн хэрэгцээ



Зураг 8: Нөөц бэлтгэлийн санхүүжилт



Эх сурвалж: Монголбанк, УХААЯ

Уг хөтөлбөрийн хүрээнд агуулахын үлдэгдэл, хөдлөх хөрөнгийг барьцаалан зээл олгож, банк барьцааны зүйлд тогтмол хяналт тавьж ажилласнаар зах зээлийн механизмд суурилсан байнгын тогтолцоо бүхий шинэ хэрэгсэл санхүүгийн зах зээлд бий болж байна. Өөрөөр хэлбэл, дунд хугацаанд Засгийн газар, Монголбанкны оролцоогүйгээр хувийн хэвшил дангаараа махны нөөц бэлтгэн нийлүүлж, нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг ханган, махны үнийн өсөлт тогтвортой, бага түвшинд байх боломж бүрдэж байна.

## О ГУРИЛЫН ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨР

Энэхүү дэд хөтөлбөрийг 2 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна.

**2013 онд:** Дэд хөтөлбөрийн хүрээнд гурилын үйлдвэрүүдийн улаан буудай худалдан авахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэхээр Монголбанкнаас дотоодын банкуудад зээл олгож, банкууд нийт 61 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 36 гурилын үйлдвэрт олгохоор төлөвлөсөн бөгөөд 23 гурилын үйлдвэрт нийт 48.7 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Үүнээс 2014 оны 4 дүгээр сарын байдлаар нийт 43.7 тэрбум төгрөгийг эргүүлэн төлснөөр 21 гурилын үйлдвэр зээлээ бүрэн буцаан төлөөд байна. Харин үлдэгдэл 5 тэрбум төгрөгийн зээлийг эргэн төлөх хуваарийн дагуу 2014 оны 7 дугаар сард төлж дуусна.

### Хөтөлбөрийн үр дүн

- Хөтөлбөрт хамрагдсан үйлдвэрүүд Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон бусад аж ахуйн нэгж, иргэдээс авсан буудайн үнийг бүрэн төлж барагдуулсны зэрэгцээ үйлдвэрлэл нь хэвийн явагдаж, 2014 оны 4 дугаар сарын 31-ний байдлаар хөтөлбөрт хамрагдсан гурилын үйлдвэрүүдийн буудайн үлдэгдэл 11.3 мянган тонн, гурилын үлдэгдэл 7.2 мянган тонн байна.
- Хөтөлбөр үргэлжлэх хугацаанд гурилын үйлдвэрүүд 141.3 мянган тонн гурил буюу хэрэгцээт гурилын 75%-ийг үйлдвэрлэсний 124.9 мянган тонн (88%)-ыг гэрээнд заасан үнээр борлуулсан.
- Аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан “Гурилын үнэ тогтворжуулах гэрээ”-ний хугацаа дууссанаас хойш буюу 2014 оны 1 дүгээр улиралд 33.6 мянган тонн гурил үйлдвэрлэж, 37.8 мянган тонн гурил борлуулаад байна.
- Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн 2012 оны 4 дүгээр сараас эхлэн 1 дүгээр зэргийн гурилын бөөний үнийн өсөлт буурч, 5, 6 дугаар саруудад 19.2 - 16.9 хувийн бууралттай байсан боловч 7 дугаар сараас өсч, оны эцэст өмнөх оны мөн үеэс 5%-иар өссөн нь улаан буудайн нөөц хомсдож үнэ өссөн, үйлдвэрүүдийн ус, цахилгаан, дулааны үнэ 15%-иар өссөн зэргээс шалтгаалсан гэж дүгнэж байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд үйлдвэрүүдэд улаан буудай худалдан авах

эргэлтийн хөрөнгийн хомсдол үүсч, үйлдвэрлэл доголдох, зах зээл дээрх гурилын нийлүүлэлт багасч, 1 кг 1 дүгээр зэргийн гурилын үнэ 760-900 төгрөгт хүрэх нөхцөл үүсэх байсан тооцоо гарсан.

**2014 онд:** Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэхдээ хүнсний бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэн, хүнсний бараа, бүтээгдэхүүний хангамжийн үр ашигтай, зах зээлийн зарчимд суурилсан байнгын тогтолцоог бүрдүүлэх зорилготой байна. УИХ-ын 2013 оны 11 сарын 14-ний 62 дугаар тогтоолын 4.1-д заасны дагуу хөтөлбөрийг зах зээлийн механизмд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлэх зорилгоор хөтөлбөрийн санхүүжилтийн 20%-ийг банкны өөрийн эх үүсвэрээр, 80%-ийг Монголбанкнаас банкинд олгосон зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэв.

#### **Өмнөх жилээс ялгарах онцлог**

Сүүлийн 5 жилд дотоодын гурилын үйлдвэрлэл болон импортоор зах зээлд нийлүүлсэн гурилын хэмжээнд үндэслэн хүн амын хэрэглээг тооцон үзэхэд Монгол Улсын нийт хүн амын гурилын жилийн дундаж хэрэглээ 191.9 мянган тонн, сарын дундаж хэрэглээ 15.99 мянган тонн байна. Харин 2014 оны 4 дүгээр сарын байдлаар гурилын нийт нөөц 52.9 мянган тонн байгаа нь хүн амын 3.0 сарын хэрэгцээг хангах боломжтой түвшинд байна.

Иймээс 2014 оны шинэ ургацын улаан буудайгаар үйлдвэрлэх гурил зах зээлд нийлүүлэх хугацаа буюу 11 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд 103.9 мянган тонн гурил буюу 138.6 мянган тонн улаан буудай шаардагдах, дутагдалтай байгаа 43.6 мянган тонн гурил буюу 58.1 мянган тонн улаан буудайн нөөцийг бүрдүүлэх, гурилын үнийг тогтворжуулах зайлшгүй шаардлага тулгараад байна.

#### **Хүснэгт 8: Гурил, буудайн үлдэгдэл\***

<b>Байршил</b>	<b>Буудайн үлдэгдэл, тонн</b>	<b>Гурилын үлдэгдэл, тонн</b>
Зээлэнд хамрагдсан 23 гурилын үйлдвэр	11,390.6	7,220.0
Тариалан эрхлэлтийг дэмжих сан	25,000.0	-
Импортолсон	12,073.1	5,432.3
Буудайн үлдэгдэл, /орон нутагт/	4,500.0	
<b>НИЙТ</b>	<b>52,963.7</b>	<b>12,652.6</b>

Жич: \*- 2014 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн байдлаар

Хөтөлбөрийн хүрээнд нөөц бүрдүүлэхэд шаардагдах санхүүжилт 57 тэрбум төгрөгийг гурилын үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээлийн хэлбэрээр шийдвэрлэснээр дотоодоос нөөц бүрдүүлсэн болон импортоор худалдан авах 125.2 мянган тонн улаан буудайгаар 93.9 мянган тонн гурил үйлдвэрлэж, гэрээнд заасан үнээр худалдаанд гаргах боломж бүрдэнэ.

Хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгжүүд нь урьдчилгаа санхүүжилтээр бүрдүүлсэн улаан буудайгаар үйлдвэрлэсэн гурилыг худалдаанд гаргаж, зээлийн эргэн төлөлтийг 14 хоног тутамд хийх бөгөөд агуулахад байгаа улаан буудай болон гурилын үлдэгдлээр баталгаа гарган дараагийн шатны зээлийн санхүүжилтийг авах хуваарийг гаргаж, банктай байгуулах гэрээнд тусгаж өгнө.

#### **О "ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗООРЬ, АГУУЛАХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ЭРЧИМЖСЭН АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ" ДЭД ХӨТӨЛБӨР**

“Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” дэд хөтөлбөр 2013 оны 11 дүгээр сараас эхлэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд уг хөтөлбөрийн

хүрээнд зоорийн багтаамжийг нийт 82.6 мянган тонноор нэмэгдүүлж, автомат, хагас автомат удирдлагатай, иж бүрэн механикжсан ажиллагаатай төмс, хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүний зоорь, агуулах, худалдааны төвүүдийг байгуулах, эрчимжсэн аж ахуйн хөтөлбөрийн хүрээнд 2014 онд 6 мянган тонн, 2015 онд 6.8 мянган тонн, 2016 онд 7.7 мянган тонн нойтон мах нийлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд энэ нь гол төлөв 2-7 дугаар сарын нойтон махны нийлүүлэлтийг 15%-иар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна.

Дэд хөтөлбөрийн хүрээнд ҮХААЯ-наас 79 аж ахуйн нэгжийн төслийг шалгаруулсан. 2014 оны 4 дүгээр сарын байдлаар Монголбанкнаас банкинд олгосон зээлийн эх үүсвэрээр банкууд нийт 111.5 тэрбум төгрөгийн зээлийг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 43 компанид олгожээ. Зээл эргэн төлөгдөх хуваарийн дагуу 2017 онд бүрэн төлөгдөж дуусна.

Хөтөлбөр хэрэгжиж эхлээд удаагүй байгаа тул үр дүн нь хараахан гарч амжаагүй байна. Гэхдээ хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хэсэг компани (Эй Эн Ди Эм ХХК, Хүнс комплекс ХХК, М Ти Эс ХХК, Тэнгэр ХХК, Траст трейд ХХК)-иудын барьж буй зоорь, агуулах 95 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байгаа нь удахгүй ашиглалтад орж, дэд хөтөлбөрийн зорилтот үр дүнд хүрэх нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

\_\_\_ооо\_\_\_

## БАРИЛГЫН САЛБАРЫГ ДЭМЖИХ, УЛМААР ОРОН СУУЦНЫ ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨР

Тус хөтөлбөрийг БХБЯ-тай хамтран 2013 оны 1 дүгээр сарын 9-ний өдрөөс эхлэн дараах үндсэн чиглэл, зорилттойгоор хэрэгжүүлсэн:


Барилгын гол нэр төрлийн материалын үнийг тогтворжуулах:

- Барилгын гол нэр төрлийн материалын дотоодын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах;
- Зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ын улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгах;
- Дэвшилтэт технологи бүхий, байгаль орчинд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх төслүүдийг дэмжих.

**2013 онд:** Засгийн газартай гэрээ байгуулсан барилгын материал үйлдвэрлэгч дотоодын аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл авч үйлдвэрлэлээ өргөтгөх боломжийг олгох, барилгын гол нэрийн материалын дотоодын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахад зориулж 71 компанид 174.7 тэрбум төгрөг, зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ын улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгахад зориулж 55 компанид 125.4 тэрбум төгрөг, нийт 301.6 тэрбум төгрөгийн зээлийг банкууд олгожээ. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр цементийн үнэ 2013 онд эхний 6 сард маш тогтвортой, 7 дугаар сараас эхлэн хэлбэлзэл нь өссөн байна. Арматурын үнэ 2013 онд тогтвортой байсан нь хөтөлбөрт хамрагдсан ААН-үүд гэрээнд заасан үнээр арматурыг борлуулж, гэрээний үүргээ биелүүлсэнтэй холбоотой.

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд барилгын салбар 2013 онд 66.5%-ийн өсөлттэй гарч, үндсэндээ уул уурхайн салбарын орон зайг 2013 онд нөхсөн. Ингэснээр ДНБ-ий бодит өсөлтийг хоёр оронтой тоонд хадгалж, хөдөлмөрийн зах зээлд ажлын байрыг хамгаалахад чухлаар нөлөөлсөн юм.

Зураг 9: Арматур, цементийн үнэ /сараар, мянган төгрөг/



Эх сурвалж: БХБЯ

2014 оны эхний улиралд дэд хөтөлбөрийн хүрээнд ердөө 3 тэрбум төгрөгийн зээлийг банкууд барилгын материалын дотоодын үйлдвэрлэгчдэд олгосон бөгөөд дэд хөтөлбөрийн хүрээнд нэмж зээл гаргахааргүй байна. Энэ нь 2013 онд барилгын материалын дотоодын үйлдвэрлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээл олгож, дотоодын үйлдвэрлэлийг бодитой дэмжсэн, барилгын материалын нийт хэрэгцээнээс дотоодын үйлдвэрлэлээр хангах хувь хэмжээ нь өсөн нэмэгдэж байгаа, энэ оноос эхлэн улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгах зорилгоор цемент, арматурын импортыг санхүүжүүлэх шаардлагагүй болж, энэхүү арга хэмжээг зогсоосон зэрэгтэй холбоотой байна.

## **НҮҮРСНИЙ АЮУЛГҮЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ, ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНЭ, ТАРИФЫГ ТОГТВОРЖУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨР**

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 186 дугаар тогтоолын 7 дахь заалтыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч, Эрчим хүчний Сайдын хамтарсан 2013 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн А-148/95 дугаар тушаал, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 8 дугаар сарын 7-ны А/163 дугаар тушаал, Монгол Улсын Төрийн өмчийн хорооны 2013 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 479 дугаар тогтоол гарснаар “Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ тогтворжуулах” дэд хөтөлбөрт эрчим хүчний салбарын 18 үйлдвэр, компаниуд 2 жилийн хугацаатайгаар хамрагдсан бөгөөд дэд хөтөлбөрийн хүрээнд 80 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгохоор төлөвлөсөн.

### **Хөтөлбөрийн гол зорилго**

Түлш, эрчим хүчний салбарын төрийн өмчит компани (ТӨК)-иудын санхүүгийн чадавхийг сайжруулах замаар 2013-2014 оны нүүрсний аюулгүйн нөөц, өвөлжилтийн бэлтгэлийн ажлыг хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах.

### **Хөтөлбөрийн хэрэгжилт**

“Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрт оролцогч эрчим хүчний салбарын 18 тусгай зөвшөөрөл эзэмшигч, цахилгаан, дулаан үйлдвэрлэгч, түгээгч үйлдвэр, компаниуд нь өөрийн хөрөнгийг барьцаалж, оролцогч банкуудтай зээлийн гэрээ хийж, дэд хөтөлбөрт хамрагдсан.

Дэд хөтөлбөрт оролцогч компаниудад арилжааны банкууд 2013 оны 9 дүгээр сараас эхлэн нийт 78.7 сая төгрөгийн зээл олгохоор зөвшөөрөгдсөнөөс 16 үйлдвэр, компаниуд 74.93 сая төгрөгийн зээл авсан. 2014 оны 4 дүгээр сарын эцсийн байдлаар ТӨК-иудаас 34.11 сая төгрөгийг банкуудад эргэн төлж, 40.82 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### **Хяналт, гарсан бодит үр дүн, үнэлгээний талаар**

Эрчим хүчний яам ТӨК-ийн зээл авах зөвшөөрлийг ТӨХ-нд уламжилснаар ТӨХ-ны 479 тоот тогтоол батлагдсан. Зээл авч байгаа ТӨК-тай ЭХЯ зээлийн гэрээ байгуулан, ТНБДарга баталж, арилжааны банкуудтай хөрөнгийн баталгаа, зээлийн гэрээ, зээлийн эргэн төлөгдөх хуваарь зэрэг хууль эрх зүйн баримт бичиг бүрдүүлэн мөрдөж байна.

### **Эрчим хүчний салбарын 2013 оны үйл ажиллагааны нэгдсэн дүн**

Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч 25 компани 2013 онд 2.9 их наяд төгрөгийн хөрөнгөтэй, 10,438 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж, 456.8 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, үндсэн үйл ажиллагааны зардалд 481.4 тэрбум төгрөгийг зарцуулж, салбарын дүнгээр 65.4 тэрбум төгрөгийн үндсэн үйл ажиллагааны, 34.5 тэрбум төгрөгийн балансын алдагдалтай ажиллажээ.

Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системд 2013 онд 8 дулааны цахилгаан станц, 3 дулааны станц, 2 усан цахилгаан станц, 1 салхин парк, бусад сэргээгдэх эрчим хүчний жижиг эх үүсвэрүүдээр эрчим хүч үйлдвэрлэж, хэрэглэгчдийг цахилгаан, дулаанаар ханган ажилласан бөгөөд 5,132.2 сая кВт/цаг цахилгаан эрчим хүч, 7,076.8 мянГкал/цаг

дулааны эрчим хүч боловсруулж, цахилгаан 4,577.3 мянкВт.ц, дулаан 6,585.4 мянГкал тус тус түгээж, нийт боловсруулсан цахилгаан эрчим хүчний 14.5% буюу 726 сая кВт/цагийг, дулааны эрчим хүчний 2.6% буюу 177.6 мян.Гкал/цагийг тус тус дотоод хэрэгцээндээ зарцуулжээ.

Дэд хөтөлбөрийн үр дүн нь эрчим хүчний салбарын үйлдвэр, уурхайнуудын өрийг нэмэгдүүлэхгүй байлгах, эрчим хүч, дулааны үнэ тарифыг зах зээлийн үнэд ойртуулахад цаг хугацааны боломжийг олгох, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийг тасралтгүй найдвартай хангах, нүүрсний аюулгүй нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний үнэ, тарифт өөрчлөлт оруулах бодит шаардлага гарсан тохиолдолд тухайн оны зөвхөн 6-12 дугаар сард өөрчлөлт оруулах, ингэхдээ 1 сард ногдох тарифын өөрчлөлтийг 2%-иас ихгүй байлгах жишгийг хэрэгжүүлэх замаар зардлын шалтгаантай инфляцийн дарамт бага байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэхэд Багануур, Шивээ-Овоо, Адуунчулуун болон бусад уурхайнуудтай гэрээ байгуулан, 2013-2014 оны өвлийн оргил ачааллын үед дулааны станцуудыг нүүрсээр тасралтгүй хангаж, хэрэглэгчдийг дулааны болон цахилгааны эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангаж ажиллав. Хөтөлбөрийн хүрээнд авсан хөнгөлөлттэй зээлээс дулааны цахилгаан станцаар дамжуулан зээлдүүлэх гэрээгээр Багануурын уурхайд 18.5 тэрбум төгрөг, Шивээ-Овоогийн уурхайд 12 тэрбум төгрөгийн зээлийг өгчээ.

2013-2014 оны өвөл нүүрсний хэрэглээ өмнөх оноос 27%-иар өссөн ч, эрчим хүч, дулаан үйлдвэрлэгч үйлдвэрүүдэд урьд өмнө байгаагүй хэмжээний буюу 30-35 хоногийн нүүрсний аюулгүйн нөөц бүрдсэн /1661.1 мянган тонн буюу 38.7 тэрбум төгрөгийн нүүрс/. Нүүрсний нийт хэрэглээний 61 хувийг Багануурын уурхай, 26.6 хувийг Шивээ-Овоогийн уурхай, 11.4 хувийг Шарын голын уурхай тус тус хангаж, өвлийн оргил ачааллын үед хэрэглэгчдийг цахилгаан, дулааны эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангасан байна. Зээлийг зөвхөн зориулалтын дагуу ашиглахад тогтмол хяналт тавин ажилласны зэрэгцээ нүүрсний аюулгүйн нөөцийн чанар, стандарт, өвөлжилтийн бэлтгэл хангалтад зохих хяналт тавьсан болно.

Эрчим хүчний үйлдвэр, компаниудын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, байгаль орчин дахь сөрөг нөлөөллийг бууруулах, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч 21 компани 2013 онд нийт дүнгээр 458 үндсэн тоноглолд их засвар, 813 туслах тоноглолд их засварын ажил хийж, хөрөнгө оруулалтаар 556 нэр төрлийн ажил, техник зохион байгуулалтын арга хэмжээгээр 325 ажил гүйцэтгэж, өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангасан байна. Дээрх ажлуудыг хийхэд нийт 59.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөн батлуулж, гүйцэтгэлээр 56.1 тэрбум төгрөгийг зарцуулсан.

ЭХЯ-наас 2013 оныг ”Эрчим хүч хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх жил” болгож, хөтөлбөрт оролцож байгаа эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниуд өнгөрсөн хугацаанд дотоод нөөц бололцоогоо дайчлан, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, зардлыг бууруулан 10,708.4 сая төгрөгийн хэмнэлт гарган ажиллажээ.

Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын 2014 оны зорилтыг ЭХЯ-наас ажлын хэсэг гарган үйлдвэр тус бүрээр хэлэлцэж, 2014 онд дотоод хэрэгцээний цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэгцээг бууруулах замаар үйлдвэрлэлийн зардлыг хэмнэх, авлага төвлөрүүлэлтийг сайжруулах, хөрөнгө оруулалт, урсгал засваруудыг төлөвлөгөөний дагуу хийх, эрчим хүч, дулаан түгээлтийг нэмэгдүүлэх, борлуулалтын орлогыг өсгөх замаар үйл ажиллагааны ашгийг нэмэгдүүлэх шат дараалсан арга хэмжээ авч ажиллаж байна.

**Хөтөлбөрүүдийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, арга хэрэгслүүдийг зах зээлийн механизмд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлэх хүрээнд**

Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2010 оны 12-р сарын 9-ний өдрийн 72 дугаар тогтоолын 4 болон 8 дугаар заалтуудад эрчим хүчний салбарыг зах зээлийн механизмд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлэх талаар заасан. Энэ хүрээнд эрчим хүчний салбарын үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үр ашгийг дээшлүүлэх, өртөг зардлыг хямдруулах, үнэ тарифыг инфляцитай уялдуулан үе шаттай чөлөөлөхөд чиглэсэн арга хэмжээг авч ажиллаж байна.


“Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2014 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 34 дүгээр тогтоолын хавсралтын 4.2 дахь заалтыг шат дараатай хэрэгжүүлэх, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх зорилгоор ЭХЯ-наас Эрчим хүчний зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо, Засгийн газрын холбогдох яамдтай хамтран ажиллана.

— ооо —

**ХӨТӨЛБӨРИЙГ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН ХЭЛБЭРТ ШАТ ДАРААТАЙГААР ШИЛЖҮҮЛЭХ, ДУНД ХУГАЦААНД МОНГОЛБАНК ХӨТӨЛБӨРӨӨС ГАРАХ ТУХАЙ**

2012 оны 11 дүгээр сараас 2013 оныг дуусталх хугацаанд 5 дэд хөтөлбөрийн хүрээнд 696 тэрбум төгрөгийг банкууд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 230 орчим ААН-үүдэд олгосон бөгөөд 2014 он дуусахад олгосон зээлүүд хуваарийн дагуу эргэн төлөгдсөөр нийт зээлийн үлдэгдэл 43%-иар буурч, 397 тэрбум төгрөг болох төсөөлөлтэй байна.

Зураг 10: Хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөг /хөтөлбөр тус бүрээр, хугацааны эцэст/



Эх сурвалж: Монголбанк

Засгийн газар, Монголбанк хооронд байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн 3 дугаар зүйлд “Засгийн газар хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хэсэгтэй тэнцэх хэмжээний урт хугацаатай үнэт цаасыг эдийн засгийн чадавхид тулгуурлан хэсэгчлэн гаргана...” гэж заасан хэдий ч, Засгийн газар хөтөлбөрийг хэрэгжүүлснээс өнөөг хүртэлх хугацаанд энэ зориулалтаар үнэт цаас гаргаагүй байна.

“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр” нь: (i) иргэдийн суурь хэрэглээ болсон мах, гурил, жижиглэнгийн худалдааны шатахуун, зарим барилгын материалын үнийн өсөлтийг өмнөх жилүүдээс мэдэгдэхүйц бага байлгах, (ii) нийлүүлэлтийн гаралтай буюу зардлын шалтгаантай инфляцийн дарамтыг эрс бууруулах, (iii) эдийн засгийн бүтэц дэх гажуудал, бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамж дахь хязгаарлалтуудыг засах, (iv) санхүүгийн зах зээлд бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих нөөцийг санхүүжүүлэх шинэ бүтээгдэхүүнийг бий болгох зэрэгт чухал үүрэг гүйцэтгэлээ.

Хэрэв энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй байсан бол 2013 онд инфляци 20 гаруй хувьд хүрч өсөх, санхүүгийн болон эдийн засгийн хямрал бий болох, улмаар ажилгүйдэл огцом нэмэгдэх эрсдэлтэй байсан юм.



Монголбанк хөтөлбөрийн арга хэрэгслийг зах зээлийн механизмд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлэх ажлын хүрээнд зээлийн 20%-ийг арилжааны эх үүсвэрт шилжүүлсэн буюу банкууд өөрийн эх үүсвэрээс гаргах зохицуулалтыг 2014 оноос хэрэгжүүлж эхлэв. Цаашид зээлийн эх үүсвэр дэх Монголбанкны хувь хэмжээ буурсаар Монголбанк хөтөлбөрөөс дунд хугацаанд гарах бөгөөд үүнийг “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл” болон дэд хөтөлбөр тус бүрт тусгасан болно.

Хэдийгээр хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлж, бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үр ашигтай, зах зээлийн зарчимд суурилсан тогтолцоог бий болгох нь туйлын зорилт боловч, хөтөлбөрт Засгийн газрын оролцоо, санаачлагыг нэмэгдүүлэх, тодорхой хугацааны дараа хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үүргийг Засгийн газарт бүрэн шилжүүлэх, зээлийн санхүүжилтийг нь улсын нэгдсэн төсөвт тусгаж, түүгээр шийдвэрлэдэг байх шаардлагатай болж байна. Учир нь нийлүүлэлтийн гаралтай инфляцийн эсрэг Төв банкны хариу үйлдэл, арга хэмжээ нь байнгын шинжтэй байх боломжгүй юм. Үүнийг дараах байдлаар тайлбарлая:

2009 оноос хойш дэлхийн төв банкууд мөнгөний уламжлалт бус бодлогоор дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралтай тэмцэх буюу болзошгүй хямралын эрсдэлээс сэргийлэх болов. Ингэхдээ мөнгөний бодлого нь ихээхэн тодорхойгүй, хувьсамтгай, богино болон урт хугацаанд бодлогын шийдлээ хүлээсэн орчинд хэрэгжиж байна. Мөнгөний уламжлалт бус бодлогын зарим онцлог шинж чанарыг дурдвал банк хоорондын захын хүү түүхэн доод буюу бараг тэг түвшинд хүрсэн, үүнтэй зэрэгцээд эдийн засгийн бодит секторт мөнгөний нийлүүлэлтийг эрс нэмэгдүүлсэн, банкуудад хөрөнгө нийлүүлэх хэрэгслүүдийн хугацаа уртассан, үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон банкуудын хувьцааг Төв банкууд худалдаж авдаг болсон зэргийг дурдаж болох юм.

Монголбанкны үүрэг ч үнийн тогтвортой байдлаар хязгаарлагдалгүй эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг дэмжих, болзошгүй хямралын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бүтцийн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд оршиж байв. Инфляцийн түвшин сүүлийн жилүүдэд тогтмол 10 хувийг давж, 2 оронтой тоогоор илэрхийлэгдсээр ирсэн нь Монгол улсын бага, дунд орлоготой иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж, бодит орлогыг нь бууруулж байв. Энэхүү өндөр, савалгаа ихтэй инфляцийн дийлэнх хэсгийг нийлүүлэлтийн гаралтай буюу зардлын шалтгаантай хүчин зүйлс, тэр дундаа хүнс, шатахууны тасалдал, дэд бүтцийн түгжрэлүүд тодорхойлсоор ирсэн билээ.

Нийлүүлэлтийн шок нь заримдаа цөөн тооны нийлүүлэгчид бараа, үйлчилгээгээ зах зээлд өндөр үнээр нийлүүлэх эрмэлзлээр ч илэрч байсан юм. Ийнхүү нийлүүлэлтийн гаралтай инфляци он удаан жил өндөр түвшинд байсан нь инфляцийн хүлээлтийг ужгируулах үндсийг тавьсан юм. Инфляцийн хүлээлт ард иргэд, аж ахуйн нэгжүүдийн ой тоонд ужгирах шинжтэй болсон нь санхүүгийн гэрээ, хэлцлүүдийн үнэ (нэрлэсэн хүү)-д эрсдэлийн урамшууллыг суулгахад, ингэснээр хадгаламж, зээлийн хүүг мөн ялгаагүй хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэхэд хүргэж байлаа.

Бодит утгаараа хүүний дарамт бага мэт харагдаж байгаа боловч нэрлэсэн хүүний өндөр түвшин нь аж ахуйн нэгжүүдийн мөнгөн гүйлгээний урсгалыг бууруулах замаар эргээд инфляцид сөргөөр нөлөөлөх, санхүүгийн хэлцлийн хугацааг богиносгоход хүргэж байсан юм. Ийм орчинд нэрлэсэн хүү, тухайлбал зээлийн хүү нэг оронтой тоонд орохгүй, эдийн засагт өгөөжийн муруй бий болохгүй, улмаар хөрөнгийн захын хөгжил саатсаар байв.

Иймд, нийлүүлэлтийг гаралтай инфляцийг бууруулаагүй, нөлөөллийг нь арилгаагүй нөхцөлд инфляцийг бага түвшинд тогтворжуулах боломж туйлын хомс байгааг харгалзан Монголбанк ”Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны

хөтөлбөр”-ийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү хөтөлбөр нь өрхийн хэрэглээний суурь бараа бүтээгдэхүүн болох мах, гурил, шатахууны жижиглэнгийн худалдааны үнийн өсөлтийг бага түвшинд байлган тогтворжуулах, зах зээлийн зарчимд суурилсан агуулахын санхүүжилтийн механизмыг шинээр бий болгоход тус тус чиглэсэн билээ.

Хөтөлбөрийн хүлээгдэж байсан үр дүнгүүд гарснаар Монголбанк санхүүгийн тогтвортой байдалтай уялдаатайгаар хөтөлбөр дэх оролцоогоо үе шаттай бууруулах замаар хөтөлбөрөөс бүрэн гарах болно. Хэрэв дунд хугацааны туршид Монголбанк уг хөтөлбөрт өндөр оролцоотой хэвээр байвал хөтөлбөрт Засгийн газрын үүрэг, хариуцлага, хяналт төдийлөн сайжрахгүй байх, хөтөлбөрийн зорилгыг бүрэн дүүрэн ухамсарлахгүй байх, нийлүүлэлтийн гаралтай инфляцийг бууруулах үр ашигтай тогтолцоог бий болгоход хүндрэл, бэрхшээл учрах, хөтөлбөрийн санхүүжилт нь улсын нэгдсэн төсөвт тусгагдахгүй байх, хөтөлбөрийг улсын төсвөөс дэмжихгүй байх, санхүүгийн сөрөг зуучлалын эрсдэл нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөллүүд бий болж болзошгүй юм.

Иймд, дунд хугацаанд Монголбанк хөтөлбөрөөс гарах, хувийн хэвшил (банк, аж ахуйн нэгжүүд) хөтөлбөрийн үндсэн чиг үүргийг зах зээлийн зарчмаар нь үргэлжлүүлэх, Засгийн газраас хяналт, зохицуулалтын арга хэмжээ авах, шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгаж байх нь зайлшгүй чухал юм.

\_\_\_\_\_ооо\_\_\_\_\_